



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/463

Хэрлэн сум

Мал, амьтны шилжилт
хөдөлгөөнийг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12.-7.12.3, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолын Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд saatuulж, хорио цээрийн хяналтад авах тухай" нэгдүгээр хавсралт зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт шүлхий, үхрийн арьс товруутах, бог малын мянган, хонины цэцэг өвчин бүртгэгдэж зарим аймагт хорио цээр, хязгаарлалтын дэглэм хэрэгжиж байгаатай холбогдуулан өвчин зөөвөрлөгдөн дамжин тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор өвчин бүртгэгдсэн аймаг, sumaас өөрийн аймгийн нутаг дэвсгэрт орох зөвшөөрөлгүй отор нүүдэл, мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг 2022 оны 9 дүгээр сарын 20-оос 2022 оны 10 дугаар сарын 20-ийг хүртэл түр хугацаагаар хориглосугай.


2. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, үзлэг тандалт, дархлаажуулалт, халдвартгүйтгэлийг эрчимжүүлэх, гоц халдварт, халдварт өвчний талаарх мэдээлэл, сээрэмжлүүлгийг малчид, иргэдэд хүргэх, аймаг дотроо мал төхөөрөх цэгт нядлах үхэрт мал эмнэлгийн гэрчилгээ олгож хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газарт даалгасугай.

3. Улсын хэмжээнд үхрийн арьс товруутах өвчнийг бүрэн хяналтад авах хүртэл хугацаанд гадны аймаг, нийслэл рүү чиглэсэн амьд үхрийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, хурдан морьдын уралдаан, малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулахгүй байхыг сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



231011115